

## ҮНДЭСТЭН БА ҮНДЭСНИЙ УХАМСРЫН СЭРГЭН МАНДАЛТ

М.Мөнхзул

ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш, докторант

Судалгааны материал, арга зүй: Уг өгүүллийг бичихдээ өрнө дахины тэр дундаа ОХУ-ын судлаачдын ном зохиол, илтгэлийг түлхүү ашигласан болно. Энэхүү судалгааны ажилд нийгмийн шинжлэх ухааны ерөнхий арга болох харьцуулалтын арга, хийсвэрлэх арга, түүхэн ба логик аргыг ашиглахаас гадна олон ургальч үзлийн зарчим болон асуудалд бодитой хандах зарчмыг баримталсан билээ.

Судалгааны үр дүн: Үзэл суртлын хориг үгүй болж нийгмийн бодол санаа нь нийгмийн харилцааны хөгжлийн хүчин зүйлсээр нөхцөлдсөн сэтгэхүйн болон нийгмийн үзэгдэл болсон нөхцөлд үндэсний ухамсар нь эх орны болон дэлхийн соёлыг урлагаар хүлээн авах болжээ. “Нийгмийн бодол санааны үүрэг янз бүрийн нөхцөлд өөр өөр хүчээр илэрдэг боловч ерөнхий түүхэн хандлага нь нийгмийн бодол санааны нийгмийн үүрэг өргөсч, нийгэм-улс төрийн үр ашигтай зүйл болж хувирна. Нийгмийн бодол санаа өөрийнхөө бүх үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд мэдээлэл чөлөөтэй тарах, төлөвшин байгаа нийгмийн бодол санаа илрэх бололцоог хангасан нийгмийн зохих нөхцөл, механизм хэрэгтэй. Бас нийгмийн шинэ, сайн бодол санаа төлөвшихөд хүмүүс олон ургальч үзлээ чөлөөтэй илэрхийлэх улс төр, үзэл суртлын тодорхой нөхцөлд нэн чухал”<sup>44</sup> гэж Г.Л.Судас бичжээ. Социализм гэж нэрлэгдсэн хуучин нийгмийн үед манай улсад тийм нөхцөл байгаагүй: үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө байгаагүй, нэг үзэл суртал ноёрхож, хэн ч гэсэн тогтсон ёс дэглэмийг зөрчих эрхгүй байсан.

Германы нэрт философич Х.Е.Зандкюлер “Ардчилал, бүх нийтийн эрх, бодит олон ургальч үзэл” гэсэн өгүүлэлдээ: би өргөн утгаар олон ургальч үзэл гэдгийг чухал асуудал нэг бүрээр харилцан үгүйсгэсэн, харилцан зөрчилдсөн хариу байхыг ойлгодог юм. Ертөнцийг тайлбарлах явдал зөрчилгүй байна гэж байхгүй, учир нь энэ ертөнцөд амьдарч байгаа хүн бүхэн өөр өөр байдлаар аж төрдөг шүү дээ гэж бичсэн байна<sup>45</sup>. Түрүүчийн нийгмийн үед эрх баригчдын бодол санаанаас гадуурх бодолтой хүний нийгмийн идэвхийг дэмждэггүй байсан. Тэр үед эрдэмтэд үндэсний ухамсрын асуудлыг гаргаж тавьдаггүй байсан. Марксизм-Ленинизм философийн болон улс төрийн олон ургальч үзлийг үгүйсгэж байлаа. Гэвч олон ургальч үзэл цаг ямагт, бас одоо нийгмийн үзэгдэл хэвээрээ байсан, байж ч таарна, нийгмийн амьдралын улстөр, нийгэм, эдийн засаг, соёл-хэлний болон экологийн хүрээнд хүмүүсийн нийгмийн идэвх өрнөж, үндэстний сэргэн мандалтын өнөө үед олон ургальч үзэл чухлаар тавигдаж байна. “Олон ургальч үзэл нь нэг үзлийн ноёрхлоос татгалзах, нэг үзэл суртлын ноёрхлыг даван туулах, янз бүрийн ардчилсан тайлбар өөр хоорондоо өрсөлдөн зэрэгцэн байхыг эрхэмлэдэг юм....нэг үзлийн нөлөөний хумагдал нөгөө үзлийг

<sup>44</sup> Народонаселение // Большая Российская Энциклопедия. М., 1994. х. 574.

<sup>45</sup> Авксентьев А.В., Авксентьев В.А. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь: СГПИ, 1993. х. 3.

өргөжүүлдэг юм. Ийм юм янз бүрийн нийгмийн хүчний улс төрийн зорилгоор бий болдог, нэг нэгээ эсэргүүцсэн улс төрийн хөдөлгөөний идэвхжилтийн үед гардаг”<sup>46</sup>.

Нийгмийн амьдралыг ардчилсантай уялдан нийгмийн ухамсарт нэг үзлээс олон ургальч үзэлд шилжих боломж бий болсон. В.И.Каширин “нийгэмд бодитой байж байгаа, үзэл, байр суурийг хүлээн зөвшөөрсөн явдал нь олон ургальч үзэл нийгмийн өөрийн ухамсрын хөгжилд анхны алхам болсон юм. Энэ бол философийн гүн гүнзгий асуудал, үзэл санааны процесс дахь объектив, субъектив зүйлийн диалектик илрэл юм”<sup>47</sup> гэж бичжээ. Нийгмийн амьдралын олон ургальч үзэл байнга өөрчлөгдөж байдаг. Тэр нь үндэсний, газар нутгийн, угсаатны, соёл-түүхийн олон янзын зөрчил үүссэн үед бий болох талтай. Ийм үед нийгмийн идэвхжилтийн шалтаг болсон үндэсний ашиг сонирхол нэн чухал бөгөөд ач холбогдолтой болдог. Оросын нэрт философич В.С.Соловьев “Орос дахь үндэсний асуудал” гэдэг бүтээлдээ ард түмэн нэг бүр өөрийн гэсэн ашиг сонирхолтой байдаг бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө байдаг юм.

Ард түмний зан суртахууны үүрэг бол өөрийн хувиа бодох үзлээс татгалзах, бусад хүмүүстэй найрамдалтай байхад байдаг билээ. Ард түмэн бол бүх дэлхий дахины нэг хэсэг нь болох учир ард түмэн бүхэнтэй эв нэгдэлтэй байх учиртай”. Өнөө үеийн манай нөхцөлд В.С.Соловьевын энэ санаа улс төрийн тогтвортой байдал, олон ястан хоорондын харилцаа, эдийн засаг, хуулийн хэм хэмжээнд ч чухал ач холбогдолтой юм. Өнөө үеийн хүмүүс нийгмийн эмх журамд итгэл муутай болжээ. Энэ нь нийгэм-эдийн засаг, оюун санаа-зан суртахууны хямрал, улс төрийн олон ургальч үзэлгүй байсантай холбоотой. О.М.Соловьев “ардчилсан процессын чанарын өөрчлөлт, гүнзгийрэлтэд олон ургальч үзэл чухал үүрэгтэй. Нийгмийн олон янзын ашиг сонирхол бол амьдралын ардчилсан хэлбэрийн төлөвшилтийн эхний цэг, анхны үндэс нь байдаг билээ. Олон янзын санаа бол оюун санааны амьдралын хэм хэмжээ мөн”<sup>48</sup> гэж тайлбарлажээ. Нийгмийн амьдралын бүх салбарыг ардчилж байгаа манай өнөөгийн нөхцөлд олон ургальч үзэл нь манай нийгмийн нийгэм-улс төрийн бүтцэд, ардчилал, ил тод байдлын бүх хэлбэрт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн олон “загварын” онолд илэрч байна. Олон ургальч үзэл нь диалектик зөрчилтэй шинжтэй. Энэ талаар М.В.Кондаков “Аливаа олон ургальч үзэл-улс төрийн, нийгмийн, соёлын, шашны аль нь ч гэсэн дандаа мөргөлдөөн, гажуудал, тэмцэл байдаг...үүний улмаас эмгэнэлт явдал, шийдэж боломгүй явдал ч гардаг” хэмээн бичсэн байна.

XXI зууны босгон дээр үндэсний үзэл санаа нь угсаатны бодлого, угсаатны соёлд их чухал болжээ. Сүүлийн үед олон үндэстэн эдийн засаг, нийгэм-соёлын талаар шинэчлэгдэх замд орж байгаагийн улмаас үндэстний амьдрал, оюуны соёл болон бас үндэстэн хоорондын харилцааны соёл маш ихээр өөрчлөгдөж байна. Өнгөрсөн түүхээ ч эргэн харах боллоо. Ардчилал ил

<sup>46</sup> Болотоков В.Х., Кумыков А.М. Национально – психологические проблемы в социологии русского зарубежья.

<sup>47</sup> Авксентьев А.В., Авксентьев В.А. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь: СГУ, 1993. х. 200.

<sup>48</sup> Абдулатипов Р.Г. Ассамблея народов России на пути собирания многонационального Отечества // Ассамблея народов России. М., 1999. № 1. х. 9.

тод байдал хоёр үндэсний ухамсрын өсөлт, зан суртахууны сэргэлт, үндэстний оюун санааны сэргэлтийн үндэс болж байна. Улс төрийн шинэ ухамсар, батжиж, үндэсний ухамсар хөгжиж байгаа өнөөгийн төвөгтэй нөхцөлд олон эрдэмтэн “үндэстний амьдрал, үндэстэн хоорондын харилцан нөлөөлөх явдлыг шинэ өндөр түвшинд сэтгэх бололцоотой болгохуйц шинэ үндэстний үзэл санааг төлөвшүүлэх оролдлого хийж байна”<sup>49</sup>.

Үндэстний үзэл санаа бол үндэстний нийгмийн оюун санааны амьдралын салшгүй хэсэг, тэр нь үндэсний бүх төрлийн урлаг, утга зохиолын уран сайхны хувьд өөрийн онцлогтой бөгөөд амьдралд үнэн мөнөө харуулах чадварыг тодорхойлж өгдөг юм. Үндэсний тодорхой үзэл санаа нь урлаг, уран зохиол туурвигчдын ертөнцийг үзэх үзэл, бүтээлч онцлог чадварыг нэвт харуулдаг юм. Жишээ нь: ард түмний баатруудын тухай монголын баатарлаг туульс дэлхийн соёлын санд орж байдаг. Үндэсний үзэл санаа бол хүний ухамсарт туссан бодит байдлын тусгалыг харуулсан өргөн ойлголт болохын хамтад бодит байдалтай харилцах хүний хандлага, ертөнцийг үзэх үзлийн үндсэн зарчим болдог юм. Тийм ч учир монголын ард түмний аман бүтээлд өнө эрт үеэс ер бусын бодит бус хүчин шууд болон дам байдлаар нөлөө үзүүлж ирсэн бөгөөд түүний үзэл санааны үндэс нь дээр үеийн шүтлэгийн үзэл санаа, хожмын үеийн нэг бурхант шашны үзэл байсан юм. Үндэсний үзэл санаа нь өөрийн гэсэн оюун санааны үнэт чанар бүхий угсаатны ахуй амьдралын бүх талыг харуулсан мөн чанартай болохын хамтад тэгж харуулах нөхцөл болдог байна.

Аливаа угсаатан нэг бүрт байгаль ертөнц болон өөрийн бас өрөөлийн үндэстний хүн, тэдний үзэл санаанд хандах өөр өөрийн харилцаа бий. Энэ харилцааны үндсэн дээр өөрийн гэсэн нийтлэгийн оюун санааны тодорхой систем, соёл бий болж хөгждөг байна. тэр нь эргээд ёс суртахуун, зан аашийн загварыг бий болгох бөгөөд тухайн үндэстний хүсүүсээс өөр үндэстний нийтлэгтэй харилцах харилцааг зохицуулна. Тэгэхдээ үндэстний үзэл санаа нь ахуйн үндэстний болон түүхийн бүх тодорхой илрэлд голлох, үнэлгээний үүрэгтэй байдаг. Энэ нь угсаатны бодит амьдрал, соёл хоёртой хамаатай. Жишээ нь: уран сайхны дүрийн үнэмшилтэй чанар, бүтээлийн нөлөөлөх хүч тухайн дүр бүтээлд шингэсэн үзэл санаанаас цаг ямагт хамаардаг. Манай сор болсон урлаг, уран зохиолын дүрд үндэсний үзэл санаа нэвт шингэсэн байдаг. Жишээлбэл, монголын нууц товчоог уншихад монголчуудын гарал үүсэл, дадал заншил, үндэсний бахархал үнэртэх шиг болдог билээ. Үзэл санаа, зохиол бүтээлийн уран сайхны үнэмшилд үндэстний сэргэлт, нийгмийн дурсгал, үндэстний процесс, үндэстнүүдийн өөр хоорондын харилцаанд нэн чухал байдаг.

Үндэстнүүдийн өөр хоорондын харилцаа тун нарийн төвөгтэй, үл ялим зүйл, гажуудал янз бүрийн алдаанд хүргэж мэдэх шинжтэй учраас энэ харилцаанд үндэсний үзэл санаа маш чухал үүрэгтэй. Үндэсний үзэл санаа нь зөв ч байж мэднэ, буруу ч байж мэднэ. Энэ шинж урлагийн бүтээлд их тод

<sup>49</sup> Культурология. - Ростов-на-Дону.: «Феникс», 1998. х. 106.

харагдана. В.Воровский зураач хүн хичнээн авьяаслаг байвч буруу үзэл санаа гаргасан бол... "амьдралын бодит зүйлийг өөрийн зорилгодоо тохируулсан бол, бодит амьдралыг өөрийн бодол санаандаа тааруулж зэрэмдэглэсэн бол ийнхүү амьдралын үнэнийг гуйвуулсан бол өөрийн бүтээлийн уран сайхны үнэнийг хөнөөж байгаа нь тэр" гэж тэмдэглэсэн байна<sup>50</sup>. Ийнхүү хэрэв үзэл санаа буруу, худал байх аваас бодит байдал гуйвагдана.

Үндэсний үзэл санаа маш их үүрэгтэй, тэр нь угсаатан, түүний соёлын түүхэн хөгжлийн үр дүн байдаг бөгөөд өөрийн үндэстний оюун ухаан, хүн төрөлхтний нийтлэг зүйлийн үр хөврөл нь байдаг юм. Энэ нь ард түмний үзэл санаа ялангуяа угсаатны сэргэн мандалтын үед угсаатны хувь заяанд их чухал ач холбогдолтой байдаг. Үндэсний үзэл санаа, үндэсний ухамсрын төлөвшилт, хөгжлийн бүтээгдэхүүн байдаг бөгөөд түүний хөгжил, өөрчлөлтөнд үндэстний хауй амьдралын нийгмийн болон угсаатны соёлын олон хүчин зүйл нөлөөлнө. А.В.Мазуренко "Үндэсний үзэл санаа, үндэсний ухамсар хоёр нягт холбоотой ойлголт юм. Үндэстний нийгэм-түүхийн нийтлэгийн үр дүнд үндэстний мэдрэмж, санаа сэтгэл, дадал заншил, уламжлал гэх мэтийн оюун санааны төрхөөр илэрдэг үндэстний өөрийн тухай төсөөлөл бий болдог бөгөөд үндэсний ухамсар нь үндэстний тэрхүү төсөөллийн үр дүн байдаг.

Үндэсний үзэл санааны мөн чанар нь ард түмэн-угсаатны ахуйн утга санааны асуудал байдаг. Үндэсний үзэл санааны онцлог нь үндэсний ухамсрыг нэгтгэн дүгнэж үндэстний улс төрийн анхдагчийн тухай, үндэстний оршин байх, хөгжих зорилгын тухай төсөөллийг илэрхийлдэгт байдаг юм. Үндэсний ухамсрын өөрчлөлт нь үндэстний өөрийн түүхэн ирээдүйн тухай төсөөллийг өөрчлөхөд хүргэнэ"<sup>51</sup> гэж бичсэн байдаг. Ингэхлээр энд ард түмний эрх чөлөө ч, өвөрмөц байдал ч, түүний угсаатны үнэт зүйлс ч, бас өөрийнхөө хөгжлийн зам, угсаатан хоорондын асуудлыг шийдэж ирсэн уламжлалт практикаа сонгон авах зүй ёсны шаардлага ч илэрхийлэгддэг байна. Үндэстний соёлын түвшинг дээшлүүлэх явдал нь боловсролыг хүмүүнлэг болгох, нийгмийг хүмүүнлэг болгохоос олон талаар хамаатай. Энэ хоёрыг хүмүүнлэг болгох нь үндэстний амьдралын нийгэм, зан суртахууны хуульд үндэслэгдсэн үндэсний үзэл санаа нь гол үүрэг гүйцэтгэнэ. Энэ асуудалтай холбогдуулан үндэстний сэргэн мандалтын үед үндэстэн хоорондын харьцааг тогтворжуулах нэг хүчин зүйл болсон соёлын харилцааны талаар товч авч үзэх нь нэн чухал юм.

Соёлын харилцаа нь үндэстний харилцааны олон талыг хамарсан харилцаа байдаг юм. Янз бүрийн угсаатнууд олон зууны туршид нягт харилцаа холбоотой явж, материаллаг болон оюуны үнэт зүйлсээ солилцож ирсэн байдаг. Яваа яваандаа тэдний хооронд соёлын харилцаа бий болж, өнө урьдын уламжлал, зуун зуун жилийн туршид хуримтлагдсан туршлага дээр үндэслэгдэн сайжирч хөгжиж иржээ. Үндэсний амьдралыг шинэчилж байгаа өнөө үед соёлын харилцаа нь олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, өөр өөр үзэл санаанд хүлээцтэй хандах, дадал заншил, уламжлал болон шинэ тутам төлөвшиж байгаа

<sup>50</sup> Гумилев Л.Н. Этногенез и босфера земли. - Л., 1990: х. 24.

<sup>51</sup> Рубинштейн С.Л. Основы общей психологии. - М., 1946. х. 677.

ардчилсан дадал заншил, зан төлөвийг хүндэтгэх үндсэн дээр тулгуурлавал зохино. Үндэстэн хоорондын харилцааны соёл нь үндэстний хүн амын цөөнхийн ашиг сонирхлыг анхаарах, үндэсний ёс зүйн болон гоо зүйн үнэт зүйлсийг үнэлэх, ард түмний зан төлөвтэй холбоотой үзэгдэл, процесстой бодит байдлаар харилцах явдал юм. Энэ мэтийн зүйлийг зөрчих юм бол үндэстний харилцаанд зөрчил үүсгэж үндэстний харилцааны нийгэм-сэтгэл санааны байдлыг муутгах талтай.

Нийгмийг амьдралыг ардчилах үндсэн дээр үндэстэн хоорондын харилцааг тогтворжуулах явдал нь нийгмийн шударга ёсны зарчим дээр үндэслэгдсэн соёлын харилцаанаас ихээхэн хамааралтай байдаг. Энэ үзэл санаа нь үндэсний соёлыг хамгаалан хөгжүүлэх, үндэстний ахуй амьдралын уламжлалт төлөвт тохирсон аж ахуй хөгжүүлэх замаар үндэстэн ястны эв найрамдлыг бэхжүүлэхэд туслана. Үндэстэн хоорондын харилцааны өндөр соёл нь хүмүүсийн эв нэгдлийг улам бүр бэхжүүлж, тэдний өөр хоорондын харилцан ойлголцол, харилцан хүндэтгэлийг бэхжүүлнэ. Өнөө үед дэлхий даяар харилцан ярилцах, хөршийн дотно харилцаа тогтоох, харилцан буулт хийх, тэвчээртэй хандах үзэл санаанд орж байна. Үндэсний асуудалд шийдвэрлэвэл зохих маш олон асуудалд гарч ирсэн орчин үеийн шилжилтийн нөхцөлд оюуны соёлыг сэргээн хөгжүүлэх зорилт чухал болж байна. Оюуны соёл нь ухамсар, зан суртахуун, танин мэдэхүй, хүмүүжил, гэгээрэл, хууль зүй, философи, ёс зүй, гоо зүй, шинжлэх ухаан, урлаг, үлгэр домог, шашныг багтаасан өргөн ойлголт юм. Бас оюун санааны сэргэн мандалтын салшгүй хэсэг болсон оюун санааны шинэ шинэ хэлбэр, шинэ эрмэлзэх зүйл, шинэ үзэл санаа бий болж байна.

Үндэстний сэргэн мандалт нь үнэт чанарын үүднээс үйл явдал, нөхцөл байдлыг түргэн хугацаанд үнэлэн дүгнэж чаддаг чадварлаг, биеэ даасан сэтгэлгээтэй бие хүнийг төлөвшүүлэхийг шаардаж байна. Ийм учраас шинжлэх ухаан-онолын зохих мэдлэгтэй хүнийг бэлтгэх боловсролын систем хэрэгтэй юм. Энэ шаардлагын улмаас сүүлийн үед боловсрол, түүний дотор манай нийгмийн оюун санааны хөгжилд багагүй өөрчлөлт гарч байна. Энэ шаардлагаас боловсролын системд бие хүнийг сургаж хүмүүжүүлэх үйл ажиллагааг нухацтай судлах хэрэгтэй болжээ. Орчин үеийн боловсрол нь бас гарал үүсэл, агуулгаараа түүхийн үетэй холбоотой оюуны үнэт зүйлсийг мэдэхтэй холбоотой учир түүх, улс төр, философи, сэтгэл судлал, сурган судлалыг судалж залуу үеийг зан суртахууны хүмүүжлээр хүмүүжүүлэхэд анхаарах хэрэгтэй болж байна. М.С.Каган "Хүмүүжил гэдэг нь нийгмийн үнэт зүйлсийг бие хүний үнэт зүйлс болгон хувиргах арга зам юм. Энэ нь гагцхүү бусад хүний үнэт зүйлстэй харилцах харилцааны үр дүнд бий болно"<sup>52</sup> гэж хэлсэн байдаг. Бие хүнийг өв тэгш хөгжүүлэхэд хүмүүнлэг үзэл санаа, нийт хүн төрөлхтний оюун ухаан-зан суртахууны үнэт чанар болсон үндэстний соёлыг харилцан хүндэтгэх, бүх ард түмний нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралын хүрээнд тэгш эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх үзэл санаа чухал байдаг.

<sup>52</sup> Поршнев Б.Ф. Социальная психология и общественная практика. М., 1966. х. 95.

Боловсролыг энэрэнгүй, хүмүүнлэг болгох нь орчин үеийн нөхцөлд нийгмийн цаашдын хөгжил, бие хүнийг төлөвшүүлэхэд нэн чухал болж байна. Оюуны үнэт зүйлсийг хадгалагч нь хэл байдаг. Ард түмэн нэг бүрийн хувьд хэл түүхээ мэдэх эх сурвалж, хэрэгсэл нь болдог. Ард түмний хосгүй соёл, уламжлал, дадал заншил нь хэлээр дамжиж байдаг. Угсаатан нэг бүр олон зууны түүхийнхээ туршид дуу, домог, зүйр цэцэн үг, тууль, үлгэр мэтийн үнэлж баршгүй оюуны баялгийг бий болгож үе дамжуулан уламжлуулан иржээ. Энэ талаар эх хэл угсаатны соёлын баялаг үзэгдлийг хадгалагч нь, үндэсний үзэл санааг авч явагч нь юм.

Нийгмийн амьдралын нийгэм-эдийн засгийн, нийгэм-улс төрийн, оюун санаа зан суртахууны бүх хүрээнд сэргэн мандалт болж байгаа нөхцөлд үндэсний соёлын хөгжлийн үндсэн зүй тогтлыг судлах явдал туйлын чухал болж байна. Аливаа соёл нь нийт хүн төрөлхтний соёлын салшгүй хэсэг нь байдаг болохоор бусад үндэстний, нийтийн зүйлс үндэстний зүйлд орж ирэх нь үндэстний сэргэн мандалт, нийгмийн оюун санааны хөгжлийн чухал нэг зүй тогтол байдаг. Соёл дахь үндэстний болон нийт хүн төрөлхтний харилцан холбоо, харилцан нөхцөлдсөн байдлыг тэмдэглэхийн хамтад үндэсний явцуурал, хуучинсаг үзэл хоёрыг шүүмжилж Кайсын Кулиев "Цааш явахын тулд өөрийнхөө өмнөх үеийнхэн юу юу хийснийг мэдэх ёстой. Үндэстний аливаа явцуурал агуулга хэлбэрийн аль алинд хор учруулдаг юм. Урлаг дахь жинхэнэ үндэсний, нутгийн хязгаарлагдмал байдал хоёр бүр өөр өөр зүйл юм.

Ертөнцийг үзэх үзэл дэх хязгаарлагдмал байдал, явцуурал хоёр бүтээлийн сүр сүлдгүйтэй, хоцрогдол, хуучинсаг үзэлтэй холбоотой<sup>53</sup> хэмээн бичсэн байдаг. Үндэстний сэргэн мандалт угсаатны онцлог, угсаатны нэг бүрийн ашиг сонирхлыг харгалзаж байхыг шаардана. Үүнгүйгээр аливаа үндэстний соёлын хөгжил дэх түүхэн зүй тогтол, хөгжлийн дэвшилт хандлага хоёрын тусгал болсон нэгдмэл процесс байхгүй болно. Соёлын процессын харилцан холбоо, харилцан нөхцөлдсөн байдлыг олж тогтоох нь үндэсний ухамсрын төлөвшилт, үндэстэн хоорондын харилцааг сайжруулахад шинжлэх ухааны-онолын асар их ач холбогдолтой байдаг.

Ард түмэн бүхний хувьд нийгэм-эдийн засгийн нөхцөл нь нийтлэг шинжтэй. Энэ үйлдвэрлэлийн, соёлын, гэр бүлийн нөхцөл нийт хүн төрөлхтний сэтгэхүйн болон угсаатны соёлын төлөвшилтэд үндэс нь болдог. Энэ тухай В.Е.Давидов, Ю.А.Жданов "Кавказ, Андын нуруу, Гимлай, Кордильерийн ууланд аж төрж байгаа ууланд ард түмнүүдийн ахуйн соёлын хэлбэрийг харьцуулж үзэхэд газар нутгийн байдал соёлын үйлчлэлд гайхалтай олон шинжийг бий болгодог нь харагдана. Мөн Халуун орны бүс, Туйл, далайн арал, тал нутагт аж төрдөг ард түмний хувьд бас иймэрхүү байдаг. Энэ маягийн тодорхой судалгаа тун сургамжтай. Энэ бүхэн соёлын угсаатны өвөрмөц онцлогийг тайлбарлахад түлхүүр болж өгнө"<sup>54</sup> гэж бичжээ. Бусадтай харьцуулах нь ард түмний соёл дахь үндэсний онцлог, нийт хүн төрөлхтний шинжийг танин мэдэхэд туслана. Соёлын

<sup>53</sup> Агаев А.Г. Националогия: Философия национальной экзистенции, Махачкала: Изд-во ДГУ, 1992. х. 87.

<sup>54</sup> Фоминых В.П. Общественная психология сельских жителей Чувашии. Чебоксары, 1990. х. 170.

харилцаа нь үндэстний харилцааны олон талыг хамарсан харилцаа байдаг юм. Янз бүрийн угсаатнууд олон зууны туршид нягт харилцаа холбоотой явж, материаллаг болон оюуны үнэт зүйлсээ солилцож ирсэн байдаг. Яваа яваандаа тэдний хооронд соёлын харилцаа бий болж өнө урьдын уламжлал, зуун зуун жилийн зуршид хуримтлагдсан туршлага дээр үндэслэгдэн сайжирч хөгжиж иржээ. Үндэстний амьдралыг шинэчилж байгаа өнөө үед соёлын харилцаа нь олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрөх, өөр өөр үзэл санаанд хүлээцтэй хандах, дадал заншил, уламжлал болон шинэ тутам төлөвшиж байгаа ардчилсан дадал заншил, зан төлөвийг хүндэтгэх үндсэн дээр тулгуурлавал зохино.

Үндэстэн хоорондын харилцааны соёл нь үндэстний хүн амын цөөнх ашиг сонирхлыг анхаарах, үндэстний ёс зүйн болон гоо зүйн үнэт зүйлсийг үнэлэх, ард түмний зан төлөвтэй холбоотой үзэгдэл, процесстой бодит байдлаар харилцах явдал юм. Энэ мэтийн зүйлийг зөрчих юм бол үндэстний харилцаанд зөрчил үүсгэж үндэстний харилцааны нийгэм-сэтгэл санааны байдлыг муутгах талтай. Нийгмийн амьдралыг ардчиллах үндсэн дээр үндэстэн хоорондын харилцааг тогтворжуулах явдал нь нийгмийн шударга ёсны зарчим дээр үндэслэгдсэн соёлын харилцаанаас ихээхэн хамааралтай байдаг. Энэ үзэл санаа нь үндэстний соёлыг хамгаалан хөгжүүлэх, үндэстний ахуй амьдралын уламжлалт төлөвт тохирсон аж ахуй хөгжүүлэх замаар үндэстэн ястны эв найрамдлыг бэхжүүлэхэд туслана. Үндэстэн хоорондын харилцааны өндөр соёл нь хүмүүсийн эв нэгдлийг улам бүр бэхжүүлж, тэдний өөр хоорондын харилцан ойлголцол, харилцан хүндэтгэлийг бэхжүүлнэ.

Өнөө үед дэлхий даяар харилцан ярилцах, хөршийн дотно харилцаа тогтоох, харилцан буулт хийх тэвчээртэй хандах үзэл санаанд орж байна. Үндэстний асуудалд шийдвэрлэвэл зохих маш олон асуудалд гарч ирсэн орчин үеийн шилжилтийн нөхцөлд оюуны соёлыг сэргээн хөгжүүлэх зорилт чухал болж байна. Оюуны соёл нь ухамсар, зан суртахуун, танин мэдэхүй, хүмүүжил, гэгээрэл, хууль зүй, философи, улс төр, гоо зүй, шинжлэх ухаан, шашныг багтаасан өргөн ойлголт юм. Бас оюун санааны сэргэн мандалтын салшгүй хэсэг болсон оюун санааны шинэ шинэ хэлбэр, шинэ эрхэмлэх зүйл, шинэ үзэл санаа бий болж байна.

Хүн төрөлхтний түүх нь угсаатны олон янзын хэл, соёлын холбоогоор дүүрэн байдаг. Нийгмийн хүн судлалын мэргэжилтнүүд язн бүрийн газар нутаг, ард түмний соёлыг судлах замаар саяхан болтол мэдэгдэхгүй байсан нэг чухал зүй тогтлыг нээжээ. Энэ тухай Франц Боас “тийм судалгааны явцад бид өөр хоорондоо ямар нэгэн холбоотой гэж үзэхийн аргагүй ард түмнүүдэд нэг ижил зан заншил, нэг ижил төсөөлөл байгааг илрүүлсэн юм. Тэгээд ч бид тэдэнд түүхийн нэг гарал үүсэл байдаг юм биш биз гэж үзэж чадахгүй, харин түүхийн шалтгаанаас өөр нэг ижил биш ч гэсэн төсөөтэй үзэгдлийг үүсгэдэг ямар нэгэн хууль байдаг эсэхийг судлах ёстой юм байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм”<sup>55</sup> гэжээ. Ийнхүү А.Радклиф-Браун нийгмийн амьдралын хуулийг судлах хоёр дахь чухал зорилт гарч ирж байна гээд “өөр хоорондоо түүхэн холбоогүй соёлын сан

<sup>55</sup> Дементьев В. Кайсын Кулиев. Нальчик: Эльбрус, 1988. х. 31.

хөмрөгт төсөөтэй зүйл илэрч байгаа нь хүн төрөлхтний оюун ухаангаар сайгүй нэг ижил хуулиар хөгждөг юм биш биз гэсэн дүгнэлтэнд хүрч мэдэх юм”<sup>56</sup> гэсэн байна. Энэ талаар Америкийн уугуул хүмүүс Монголоос очсон гэх мэтийн үзэл, мөн Гирландын мөсөн гэртний хэлэнд монгол маягийн үг их байдаг гэх мэтийн үзэл санаа нэлээдгүй байгаа. Энэ бүхэн нэг ч ард түмэн хэзээд ч өөр ард түмнээс салангид байгаагүй, нэг ч ард түмэн өөр ард түмний соёлоос хүртэж байгаагүй, байх учир байхгүй гэдгийг харуулж байна. Үүнээс аливаа ард түмэн дэлхийн соёл, хүн төрөлхтний үнэт зүйлт өөрийн хувь нэмрээ оруулдаг гэсэн дүгнэлт гарч байна. Энэ талаар Р.Абдулапитов “дэлхийн соёл-иргэншил бүхэлдээ ард түмнүүдийн харилцаа, ухамсар, ухамсартай хамтын үйл ажиллагааны үр дүн юм”<sup>57</sup> гэсэн нь туйлын үнэн юм.

Ардчилал, нийгмийн зан суртахууныг өөрчилж байгаа өнөө үед субъектив болон объектив хүчин зүйл, түүний дотор хүмүүсийн хүмүүжил, үндэсний болон гоо сайхны ухамсрыг төлөвшүүлэхэд угсаатны соёлын холбоо тун чухал ач холбогдолтой болж байна. Эх хэл, ахуй амьдрал, уламжлал, соёл, дадал заншил, унасан газар угаасан усаа гэсэн өнө мөнхийн сэтгэл санааг үеэс үед уламжлуулах нь угсаатны олон зуун дамжин оршин тогтнож ирсэн гол хүчин зүйл мөн. Үндэстний сэтгэхүй, үндэстний шинж чанар нь нийгэм-эдийн засаг, улс төрийн харилцааны урт удаан хөгжлийн үр дүнд төлөвшдөг байна. Үндэстний шинж чанар нь биологийн биш, харин нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд удамшихгүй. Манай орноор жуулчилсан Оросын жуулчид Монгол үндэстний өвөрмөц онцлогийг онцлон дурьдаж монголчууд эрэлхэг, эрх чөлөөг эрхэмлэсэн, нэр төрөө хамгаалсан, өөрийн газар нутгаа дээдийн дээдэд эрхэмлэдэг, ахмад настнаа гүнээ хүндэтгэдэг, зочломтгой зантай бөгөөд энэ зан заншил нь тухайн үндэстний ахуй амьдралын өвөрмөц онцлогийн үр дүнд бүрэлдэн бий болжээ гэж дүгнэсэн байдаг.

Хүмүүсийн идэвх, өөрийн ухамсар түүхэн хөгжлийн үе бүрд өөр өөрөөр илэрдэг болохоор манай нийгмийн эдийн засаг, улс төр, соёлын амьдралд эргэлтийн үе болж байгаа өнөө үед ихээхэн өөрчлөгдөх нь дамжиггүй. Ард түмний хувь заяа нь зан суртахууны төрх өөрчлөгдөж байгаа нөхцөлд үндэстнүүдийн харилцаанд ч бас өөрчлөлт гарна. Ард түмэн бүр өөрийн оршин байсан хугацааны туршид оюун санааны асар их баялгийг өөрийн өвөрмөц соёлыг бий болгодог. Угсаатан нэг бүр өөрийн гэсэн газар нутаг, цаг хугацаанд оршин байдаг, өөрийн гэсэн генийн сантай, биологийн болон нийгмийн холбоо харилцаагаар холбогдсон, ийм холбоо харилцаагүйгээр нэг ч ард түмэн оршин байх үндэсгүй. Үндэстний гэдэг нь нийгмийн хөгжлийн чухал нарийн хүчин зүйл юм. Үндэсний онцлог, бас үндэсний үзэл санаа хоёр нийгмийн хөгжлийг олон талтай болгоно. Нийгмийн хөгжлийн хэлбэр, өнгө төрхийг өөрчлөнө.

Гэхдээ онцгой, тусгай гэдэг нь нийтлэг зүйлээс эх авсан байдаг. Ийм учраас үндэсний-өвөрмөц гэдгийг нийт хүн төрөлхтний зүйлээс салгаж болохгүй.

<sup>56</sup> Репрессированные народы: история и современность. Карачаевск: КЧГПУ, 1994. х. 36.

<sup>57</sup> Хоперская Л.Л. Современные этнополитические процессы на Северном Кавказе: концерция этнической субъективности. Ростов н/Д., 1997. х. 52.



А.Ю.Шадж “Ард түмний амьдрал дахь үндэсний интернационалист хоёрын харьцаа эдийн засаг, нийгэм, оюун санаа, улс төрийн хүчин зүйлээр нөхцөлдсөн байдаг. Тэгэхдээ үндэсний гэдэг нь өөртөө зөвхөн тухайн ард түмэнд байдаг үндэсний-өвөрмөц зүйлээс гадна бусдаас ямар нэгэн хэмжээгээр өөрчилж авсан зүйлийг багтаасан байдаг. Үндэснийх дангаараа оршин хөгжиж чадахгүйн адил интернационалист зүйл үндэсний зүйлгүйгээр утгагүй болно” гэж дүгнэжээ. Р.Абдулатипов “Үндэстэн гэдэг нь хүн төрөлхтөн гэж нэрлэгддэг бүхэл бүтэн ертөнцийн олон янзын хэлбэрийн нэг нь юм”<sup>58</sup> гэж хэлжээ.

Ард түмэн нэг бүрийн үндэсний онцлог нь түүхэн ёсоор бүрэлдсэн байдаг. Ард түмэн нэг бүр соёлын дэвшилд хүрэх ижил чадвартай бөгөөд оюун санааны хөгжил өөрийн гэсэн чухал хувь нэмрээ оруулж байдаг юм. Соёл бол угсаатны бүтээлч чадамжийн үндсэн илэрхийлэгч, түүхэн хөгжлийн үндсэн зорилт байдаг болохоор бүрэн үнэ цэнэтэй, хүн төрөлхтний ач холбогдол бүхий үндэсний соёл ард түмнийг мөхлөөс хамгаалдаг юм. Янз бүрийн угсаатны соёлын холбоо харилцаа, харилцан нөлөөлцлийн асуудалд нь угсаатны соёл үндэсний ухамсрын төлөвшилтөнд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл болохыг харуулдаг юм.

#### ДҮГНЭЛТ

Үндэсний ухамсар, үндэсний үзэл санаа хоёр тусгаар тогтносон улсын өөрийгөө жолоодох, өөрийгөө зохион байгуулахын үндэс, нийгэм-улс төрийн амьдралын илэрхийлэл болдог учраас нийгмийн амьдралыг шинэчилж байгаа нөхцөлд угсаатны соёлын харилцаа холбоо нэн чухал ач холбогдолтой болж байна. Үндэсний сэргэн мандалтын асуудал нь нийгмийг шинэчлэхтэй салшгүй холбоотой. Угсаатны соёлын холбоо нь үндэстнүүдийн харилцан ойлголцол, үндэстнүүдийн зэрэгцэн оршихуйд тэвчээртэй хандах, тэдний ёс суртахуун, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууныг хүндэтгэх явдлыг илэрхийлж ирсэн байдаг бөгөөд “хүн төрөлхтний түүх угсаатны бүлгүүдийн холбоо, хэл, соёл зэргээрээ хутгалдан холилдож ирсэн түүхээр дүүрэн байдаг. Өөр угсаатны соёл, бие махбодийн шинжээр тэжээгдээгүй туйлын цэвэр угсаатан гэж огтхон ч байхгүй бөгөөд байх ч үндэсгүй” байдаг байна. Үндэстний сэргэн мандалт гэдэг бол зөвхөн эдийн засгийн хувьд бус бас соёл, зан суртахууны талд ч нарийн төвөгтэй, хэцүү бэрх асуудал байдаг. Энэ бол угсаатан ястнуудын болон бие хүмүүсийн харилцаанд туулж байгаагүй шинэ зам байх болно. Хүн, хүний нийгмийн амьдралд бэрхшээл, ашиг сонирхол, үзэл санааны хувьд зөрчилдөөн, маргаан гарч байдаг боловч гагцхүү түүнийг зохицуулж зөв замд нь оруулж байх нь хамгаас чухал байдаг. Үндэстэн угсаатан бүр өөрийн өвөрмөц онцлогтой байдаг байхад түүнийг харгалзаж үзэхгүй бол алдаа эндэгдэл гарна.

<sup>58</sup> Актуальные проблемы развития межнациональных отношений в СССР. Нальчик: КБГУ, 1989. х. 159.

**Түлхүүр үг:** Үндэстэн, үндэсний ухамсар, үндэстний сэргэн мандалт, угсаатны соёл.

**Товч хураангуй:** Сүүлийн үед олон үндэстэн эдийн засаг, нийгэм-соёлын талаар шинэчлэгдэх замд орж байгаагийн улмаас үндэстний амьдрал, оюуны соёл болон бас үндэстэн хоорондын харилцааны соёл маш ихээр өөрчлөгдөж байна. Ардчилал ил тод байдал хоёр үндэсний ухамсрын өсөлт, зан суртахууны сэргэлт, үндэстний оюун санааны сэргэлтийн үндэс болж байна. Улс төрийн шинэ ухамсар, батжиж, үндэсний ухамсар хөгжиж байгаа өнөөгийн төвөгтэй нөхцөлд олон эрдэмтэн “үндэстний амьдрал, үндэстэн хоорондын харилцан нөлөөлөх явдлыг шинэ өндөр түвшинд сэтгэх бололцоотой болгохуйц шинэ үндэстний үзэл санааг төлөвшүүлэх оролдлого хийж байна”

## РЕЗЮМЕ

Национальный оптимизм насильственно высланных народов опирался на многие факторы. Одним из них была национальная идея, концепция которой прошла в своем развитии длительный и сложный путь и нашла свое проявление в народных традициях и обычаях. Они тоже сыграли свою определенную роль в процессе выживания наказанных людей. Народные традиции и обычаи – это связующие духовно-нравственные нити между поколениями нации, и они, безусловно, влияли на национальный оптимизм ссыльных народов, которые как могли, помогали друг другу, выручали из беды, вместе строили жилища, объединяя усилия в быту, поддерживали добрым словом и советом оступившихся, отчаявшихся. Это тоже послужило одной из причин выживания нации, не позволив ей раствориться в другой. Познание социального феномена национального оптимизма и национальной идеи, как и познание природы, бесконечно.

## НОМ ЗҮЙ

1. Народо́население //Большая Российская Энциклопедия. М., 1994.
2. Авксентьев А.В., Авксентьев В.А. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь: СГПИ, 1993.
3. Болотоков В.Х., Кумыков А.М. Национально – психологические проблемы в социологии русского зарубежья.
4. Абдулатипов Р.Г. Ассамблея народов России на пути собирания многонационального Отечества //Ассамблея народов России. М., 1999. № 1.
5. Культурология. - Ростов-на-Дону, : «Феникс», 1998.
6. Гумилев Л.Н. Этногенез и босфера земли. - Л., 1990.
7. Рубинштейн С.Л. Основы общей психологии. - М., 1946.
8. Поршнев Б.Ф. Социальная психология и общественная практика. М., 1966.
9. Агаев А.Г. Нациология: Философия национальной экзистенции, Махачкала: Изд-во ДГУ, 1992.
10. Фоминых В.П. Общественная психология сельских жителей Чувашии. Чебоксары, 1990
11. Дементьев В. Кайсын Кулиев. Нальчик: Эльбрус, 1988.
12. Репрессированные народы: история и современность. Карачаевск: КЧГПУ, 1994.
13. Хоперская Л.Л. Современные этнополитические процессы на Северном Кавказе: концепция этнической субъективности. Ростов н/Д., 1997.